

БАЯНХОНГОР АЙМГИЙН 2023 ОНЫ БОДЛОГЫН
БАРИМТ БИЧИГ, ХУУЛЬ ТОГТООМЖИЙН
ХЭРЭГЖИЛТ, ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГЫН
ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ,
ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН ТАЙЛАН

2023 оны 02 дугаар сарын 28

Номгон

Баянхонгор аймгийн Засаг даргын Тамгын газрын 2023 онд бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэр, байгууллагын үйл ажиллагаанд Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ыг удирдлага болгон хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, хэрэгжилтийн үр дүнгийн талаар орон нутгийн удирдлагууд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрыг үнэн зөв, бодитой мэдээллээр хангаж, www.unelgee.gov.mn цахим санд байршуулж, ил тод байдлыг ханган ажилласан.

Аймгийн 2023 онд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний тайланг Монгол Улсын Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт тайлагнасан бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэр, байгууллагын үйл ажиллагааны тайланд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээ, Нутгийн захиргааны байгууллагуудын үйл ажиллагаанд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээ болон бусад ажил гэсэн 2 бүлэг болгон танилцуулъя.

Нэгдүгээр бүлэг: Монгол Улсын Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газарт тайлагнасан бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэр, байгууллагын үйл ажиллагааны тайланд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээ:

Баянхонгор аймгийн бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэр, байгууллагын үйл ажиллагааны тайланд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээг Засгийн газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн цахим сан болон Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын monitoring.ags.gov.mn ний дүгнэлт, илтгэх хуудсыг тайлан тус бүртэй хүргүүлсэн тул энэхүү тайланд тоймлон дурдъя.

Нэг.Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний тойм:

Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтэд 2022, 2023 оны жилийн эцэс, 2023 оны эхний хагас жил, 2023 оны 2-11 дүгээр сарын байдлаар 12 удаа хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, Засгийн газрын хэрэг эрхлэх газрын цахим системээр хугацаанд нь тайлагнасан байна. Хэрэгжилтийн дэлгэрэнгүй товчоог хүснэгтэд үзүүлэв.

Д/д	Тайлагнасан хугацаа	Хэрэгжилтийн хувь	Хяналтад авсан арга хэмжээний тоо	100 хувь	90 хувь	70 хувь	50 хувь	30 хувь	0 хувь	Хугацаа болоогүй/үнэлэх боломжгүй
1	2	3	4	5	6	7	8	9	10	11

1	2	3	4	5	6	7	8	9	10	11
1	2021 оны жилийн эцэс	81.18%	17	5	4	7	-	1	-	-
2	2022 оны жилийн эцэс	66.67%	18	2	2	7	6	1	-	-
3	2023 оны эхний хагас жил	51.11%	18	6	-	4	7	1	-	-
4	2023 оны жилийн эцэс	94.71%	18	14	-	3	-	-	-	1

Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж аймгийн Засаг дарга, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга, сумдын Засаг дарга, Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга нарт Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрөөс удаашралтай байгаа 7 заалтыг хэрэгжүүлэх, төсөв батлах талаар албан бичиг хүргүүлэн ажилласны үр дүнд 2023 оны аймгийн хөгжлийн жилийн төлөвлөгөөнд 531.9 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий дараах ажлыг тусган хэрэгжүүлснээр 2023 оны жилийн эцсийн байдлаар хэрэгжилт 94.71 хувьд хүрсэн. Үүнд:

-Тэрбум мод арга хэмжээнд 300.0 сая төгрөг;

-Гол, горхи, булаг шанд рашааны эхийг хамгаалах, усны сан бүхий газар, усны эх үүсвэрийн онцгой болон энгийн хамгаалалтын зураглал хийх 10.0 сая төгрөг;

-Хуучин хогийн цэгт техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийх 19.9 сая төгрөг;

-Хог хаягдлын менежмент нэвтрүүлэх 22.0 сая төгрөг;

-Эко бие засах газар - Баянхонгор сумын 300 өрхийг эко бие засах газартай болгох 180.0 сая төгрөг;


Хоёр.Монгол Улсын 2024 оны хөгжлийн төлөвлөгөөний хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний тойм:

Тайлант хугацаанд Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнөөс 22 арга хэмжээ хуваарилагдан 2023 оны эхний хагас жил, 9, 10, 11 дүгээр сар болон 2023 оны жилийн эцсийн байдлаар 6 удаа Засгийн газрын хэрэг эрхлэх газрын цахим системээр хугацаанд нь тайлагнасан байна. Хэрэгжилтийн дэлгэрэнгүй товчоог хүснэгтэд үзүүлэв.

Д/д	Тайлагнасан хугацаа	Хэрэгжилтийн хувь	Хяналтад авсан арга хэмжээний тоо	100 хувь	90 хувь	70 хувь	50 хувь	30 хувь	0 хувь
1	2	3	4	5	6	7	8	9	10
1	2023 оны эхний хагас жил	80.91%	22	10	3	5	2	2	-
2	2023 оны 8 дугаар сар	61.82%	22	7	3	4	1	2	5
3	2023 оны 9 дүгээр сар	74.09%	22	5	8	5	-	2	-
4	2023 оны 10 дугаар сар	84.09%	22	7	6	8	1	-	-
5	2023 оны 11 дүгээр сар	82.73%	22	6	8	5	3	-	-
6	2023 оны жилийн эцэс	96.36%	22	18	3	-	1	-	-

Гурав.Баянхонгор аймгийг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний тойм:

Баянхонгор аймгийг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн хэрэгжилтэд 2023 оны жилийн эцсийн байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж тайлагнасан. Баянхонгор аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 2/6 дугаар тогтоолоор батлагдсан “Баянхонгор аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх үндсэн чиглэл”-ийн 8 бүлэг, 8 зорилго, 24 зорилт, 105 ажил арга хэмжээг хэрэгжүүлэн ажилласан байна. Хэрэгжилтийн дундаж 94.30 хувь, дэлгэрэнгүйг зургаар үзүүлвэл:




Аймгийг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн хэрэгжилт хангалтгүй байгаа арга хэмжээнүүдийг аймгийн 2024, 2025 оны хөгжлийн төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлэх зөвлөмж өгсөн.

Дөрөв.Баянхонгор аймгийн Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтэд 2023 оны жилийн эцсийн байдлаар хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний тойм:

Аймгийн Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн тайланд Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-д заасан үнэлгээ өгөх аргачлалын дагуу үнэлгээг тооцоход дунджаар 91.65 хувьтай хэрэгжиж байна.

Хэрэгжилтийг заалтын тоогоор нь авч үзвэл:



Аймгийн Засаг даргын 2023 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлэх, тайлангийн үр дүнг чанаржуулах зорилгоор аймгийн Засаг даргын Тамгын газраас дараах арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлсэн байна.

1.Аймгийн Засаг даргын дэргэдэх 23 агентлаг, 10 орон нутгийн өмчийн байгууллага, 20 сумын Засаг даргын Тамгын газар, бодлогын хэлтсүүдийн аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтэд 2023 оны эхний хагас жилийн байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, заавар зөвлөмж өгч хэрэгжүүлэн ажилласан байна.


2.Аймгийн хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн цахим системээр (<https://bayankhongor.igovernment.mn>) Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хяналтад авах, харьяа байгууллагуудад хүргүүлэх, хэрэгжилтийг тооцох, тайлагнах, үйл ажиллагааг аймгийн хэмжээнд бүрэн цахим хэлбэрт шилжүүлж, сум, агентлагийн бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн тайланг хүлээн авч явц, үр дүнг тооцох, зөвлөмж өгөх ажлыг тогтмолжуулан ажиллалаа.

3.Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн арга хэмжээг сум, байгууллагуудад хуваарилан хэрэгжилтийг хангуулсан нь тодорхой үр дүнтэй ажил болж, байгууллагууд хоорондын уялдааг хангаж, бодит үр дүнг нэмэгдүүлэх нөхцөлийг бүрдүүлсэн байна.

Тав.Аймгийн 2023 оны хөгжлийн төлөвлөгөөнд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний тойм:

Аймгийн жилийн хөгжлийн төлөвлөгөөг Монгол Улсын Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.6-д заасны дагуу аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн 12/54 дүгээр тогтоолоор 6 бүлэг, 15 зорилт, 194 ажил, арга хэмжээг батлуулан, 90.56 хувийн гүйцэтгэлтэй хэрэгжүүлсэн байна.

Аймгийн 2023 оны хөгжлийн төлөвлөгөөний хэрэгжилт (2023 оны жилийн эцсийн байдлаар)



Цаашид төлөвлөгөө, төлөвлөлтийн баримт бичиг боловсруулахдаа Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хууль, тогтоомжид нийцүүлэн санхүүжилт болон бусад нөөцийг судалж, шалгуур үзүүлэлт, зорилтот түвшинг бодит судалгаанд үндэслэн үр дүнд суурилсан байдлаар боловсруулж, батлуулан хэрэгжүүлэх зөвлөмжийг Аймгийн Засаг даргын Тамгын газрын хэлтсүүдэд өгсөн.

Зургаа.Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтэд хийсэн хяналт шинжилгээ, үнэлгээний тойм:

Монгол Улсын Хууль, Улсын Их Хурал болон Улсын Их Хурлын Байнгын Хорооны тогтоол, Ерөнхийлөгчийн зарлиг, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн зөвлөмж, Засгийн газрын тогтоол, шийдвэр, Ерөнхий сайдын албан даалгаврын хэрэгжилтийг дүгнэн тогтоол шийдвэрийг орон нутагт үр дүнтэй зохион байгуулах, хэрэгжилтийг эрчимжүүлэх, хэрэгжилт үр дүнгийн талаар аймгийн удирдлагыг үнэн зөв мэдээллээр хангах зорилгоор 2023 онд 14 удаагийн тайланг <http://new.unelgee.gov.mn> цахим системээр тайлагналаа.

Засгийн газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний цахим санд 2023 оны жилийн эцсийн байдлаар 107 хууль тогтоомжийн 196 заалтын хэрэгжилтэйг 94.11 хувийн хэрэгжилттэй тайлагнасан.

Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт (2023 оны жилийн эцсийн байдлаар)



Баянхонгор аймгийн Засаг даргын Тамгын газраас 2023 онд хийсэн хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн дүнг дараах хүснэгтэд нэгтгэв.


Д/д	Тайлагнасан хугацаа	Нийт							Хэрэгжилтийн хувь	
		Шийдвэрийн тоо	Заалтын тоо	100 хувь	70 хувь	30 хувь	0 хувь	ХБ	Өөрийн үнэлгээ	Дээд шатны байгууллагын үнэлгээ
1	2	3	4	5	6	7	8	9	10	11
1	2022 оны жилийн эцэс	40	126	63	40	11	5	7	92.29%	79.24%
2	2023 оны I, II сар	17	27						76.67%	
3	2023 оны III сар	20	29						74.83	
4	2021, 2022, 2023 оны Засгийн газрын шийдвэрийн биелэлт	89	132	100	26	2	1	3	92.09%	92.09%
5	2023 оны IV сар	21	30						81.38%	
6	2023 оны V сар	21	30						78.00%	
7	2023 оны эхний хагас жил	56	143	63	52	15	3	10	89.85%	78.12%
8	2023 оны VII сар	34	47						86.30%	
9	2023 оны VIII сар	34	47						83.41%	
10	2023 оны IX сар	41	54	21	28	3	-	2	85.58%	78.81%
11	2023 оны III улирал (Хууль, УИХ-ын тогтоол УИХБХ-ны тогтоол)	31	121	25	26	13	4	53	87.61%	69.26%
12	2023 оны X сар	47	64						85.32%	
13	2023 оны XI сар	53	77						91.41%	
14	ҮАБЗ-ийн Зөвлөмжийн биелэлт	1	3	2	1	-	-	-	90%	90%
15	2023 оны жилийн эцэс	107	196						94.11%	

Долоо.Засгийн газрын зарим чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх гэрээний хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн тойм:

Засгийн газрын 19 гишүүнтэй Баянхонгор аймгийн Засаг даргын байгуулсан гэрээний 883 арга хэмжээг хэрэгжүүлсэн байна. Монгол Улсын Засгийн газрын гишүүн аймгийн Засаг даргатай байгуулсан гэрээний биелэлтэд хагас, бүтэн жилээр хяналт шинжилгээ, үнэлгээ хийж ажилласнаар гэрээний хэрэгжилт, үр дүн сайжирсан байна.

Сайдтай байгуулсан гэрээний дундаж 96.7 хувьтай байна.

Засгийн газрын гишүүнтэй Засаг даргын байгуулсан гэрээний хэрэгжилтийн үнэлгээ




Найм.Гадаадын зээл тусламжаар хэрэгжиж байгаа төсөл хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн тойм:

Баянхонгор аймагт хэрэгжиж байгаа Гадаадын 7 төсөл, хөтөлбөрийн 2023 оны жилийн эцсийн хэрэгжилтийн тайланд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд 98.6 хувьтай дүгнэгдлээ. Үнэлгээг хүснэгтэд нэгтгэлээ:

Д/д	Төсөл хөтөлбөр	Санхүүжүүлэгч	Хэрэгжиж буй сумдын тоо	Хэрэгжилтийн хувь
1	2	3	4	5
1	Тогтвортой Амьжиргаа-3	Дэлхийн банк	20	100%
2	Монгол унаган байгалийн хүлцэл, тогтворжилтыг хангах нь	Даян дэлхийн байгаль орчны сан	4	90%
3	Биологийн олон янз байдлыг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох	ХБНГУ-ын Засгийн газар, Сэргээн босголтын зээлийн банк, Буцалтгүй тусламж.	1	100%
4	Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох стратеги төлөвлөлтийг боловсронгуй болгох, орон нутгийн иргэдийн байгаль орчин болон байгалийн нөөцийн салбарт дасан зохицох чадавхийг бэхжүүлэх	Азийн хөгжлийн банк	4	100%
5	Best хөтөлбөр	АНУ-ын ОУ-ын Хөгжлийн агентлаг (USAID)	1	100%
6	Тогтвортой ноолуур	Дэлхийн байгаль орчны төлөө Францын Сан	7	100%
7	Эх хүүхдийн эрүүл мэндэд агаарын бохирдолын үзүүлэх нөлөөллийг бууруулах нь	НҮБ-ын Хүүхдийн сан	1	100%

Ес.Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний тойм:

Гүйцэтгэлийн төлөвлөгөөг Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 217 дугаар тогтоолоор батлагдсан “Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, гүйцэтгэлийн зорилт, шалгуур үзүүлэлт тогтоох, тайлан гаргах журам”, “Аргачлал, загвар батлах тухай” Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2020 оны 100 дугаар тушаалын дагуу 22 зорилтын хүрээнд 106 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөн, баталсан байна. Аймгийн Засаг даргын Тамгын газрын 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний 106 арга хэмжээний биелэлтийн дундаж 97.1 хувьтай байна. Дэлгэрэнгүйг доорх зурагт үзүүлэв.



Арав.Ил тод байдлын шалгуур үзүүлэлтийг хангах үйл ажиллагаанд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний тойм:

Баянхонгор аймаг нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийг хэрэгжүүлж төрийн байгууллагын ил тод, нээлттэй байхаар заасан 5 бүлэг, 46 төрлийн мэдээллийг 98 үзүүлэлтээр аймгийн албан ёсны www.bayanhongor.gov.mn болон 20 сумын албан ёсны цахим хуудсанд байршуулан хөгжүүлж ажиллаж байна.

Баянхонгор аймгийн Засаг даргын Тамгын газрын Мэдээллийн ил тод байдлын хэрэгжилтийн тайланд хяналт-шинжилгээ үнэлгээ хийхэд 45 үзүүлэлт бүрэн хэрэгжсэн, 1 үзүүлэлт хугацаа болоогүй буюу үнэлэх боломжгүй гэж үнэлэгдсэн.

Аймгийн Засаг даргын Тамгын газар, эрхлэх асуудлын хүрээний агентлаг, сумдын Засаг даргын Тамгын газрын ил тод байдлын үзүүлэлтийн хэрэгжилтийг Засгийн газрын 2022 оны 352 дугаар тогтоолоор батлагдсан “Нээлттэй мэдээллийг ил тод байлгах болон ил тод байдлын шалгуур үзүүлэлт тогтоох, үнэлгээ хийх журам”-аар 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 6.7 дахь хэсэгт заасан аргачлалын дагуу хяналт-шинжилгээ хийхэд дараах хүндрэл, бэрхшээл тулгамдаж байна. Үүнд:

1.Засгийн газрын 2022 оны 352 дугаар тогтоолоор үнэлсэн хувийг Засгийн газрын 206 дугаар тогтоолоор батлагдсан журмын дагуу хөрвүүлэн тооцоход нийт дундаж үнэлгээнд 5 хүртэл хувийн зөрүү үүсч байна.

2.Засгийн газрын 352 дугаар тогтоолоор мэдээллийн хүртээмжтэй байдлыг цахим хуудас 15, мэдээллийн самбар 10, бусад суваг 5 гэсэн заалтыг бодит байдал дээр хэрэгжүүлэхэд хүндрэлтэй байна. Өөрөөр хэлбэл хуулийн 5 бүлгийн 46 үзүүлэлтийг 98 заалтыг мэдээллийн самбарт байршуулахад олон нийтэд ач холбогдолгүй, самбарын зай талбайн хувьд багтахгүй нөхцөл байдал үүсч байна. Шилэн дансанд байршуулсан

мэдээллийг албан ёсны цахим хуудсанд байршуулсан гэж үзэх эсэх, зөвхөн байгууллагын албан ёсны цахим хуудсанд байршуулахыг цахим хуудсанд байршуулснаар тооцох эсэх нэгдсэн чиглэл байхгүй.

3.Төрийн байгууллагын хувьд Ил тод байдлын шалгуурын 5.8 дахь “Мэдээлэл хариуцагчийн явуулж байгаа үйл ажиллагаа, үйлдвэрлэл, үйлчилгээ, ашиглаж байгаа техник, технологийн хүн, мал, амьтны эрүүл мэнд, байгаль орчинд үзүүлэх буюу үзүүлж байгаа нөлөөллийн талаарх мэдээлэл” нийтлэг байдлаар хамааралгүй. Байгууллагын үйл ажиллагааны төрлөөс шалтгаалан тухай байгууллагын чиг үүрэгт 1-29 хүртэл үзүүлэлт хамааралгүй байна.

4.Босоо удирдлагатай байгууллагын хувьд бие даасан албан ёсны цахим хуудас байхгүй, дээд шатны байгууллагын цахим хуудсанд аймгийн хэлтэс, агентлаг, байгууллагын мэдээллийг байршуулдаггүй нийтлэг алдаа байна.

5.Төрийн болон орон нутгийн өмчийн байгууллагууд албан ёсны цахим хуудас хийлгэхэд санхүүгийн хувьд бэрхшээлтэй байгаа нь хуулийн хэрэгжилтийг бүрэн хангахад бэрхшээлтэй асуудал болоод байна.

Арван нэг.Сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах үйл ажиллагаанд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний тойм:

Аймгийн хүний нөөцийн хөгжлийн бодлого нь Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, аймгийн стратеги төлөвлөгөө болон аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт орсон хүний нөөцийн зорилго, зорилтыг хэрэгжүүлэх нэгдсэн хөтөлбөр болон нутгийн захиргааны байгууллагуудын бусад хөтөлбөр, төлөвлөгөөнд тусгагдан хэрэгжиж байна.

Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөрийн хэрэгжилт 95.71 хувьтай байна.

Арван хоёр.Засгийн газрын тэргүүлэх ач холбогдолтой төсөл, арга хэмжээг үнэлэх шалгуур үзүүлэлтийг биелэлтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний тойм:

Засгийн газрын тэргүүлэх ач холбогдолтой төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн хүрээнд сум, агентлагуудын үйл ажиллагааны тайлан, шалгуур үзүүлэлтийн дагуу тоон мэдээлэлд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх ажлын хэсгийг 4 чиглэлд “Сумдын Засаг даргын Тамгын газар, төсөвт байгууллагуудын 2023 оны үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх тухай” удирдамжийн дагуу сумдад ажиллан “Тэрбум мод”, “Хог хаягдлын менежментийг сайжруулах” “Цахим засаглал”-ын чиглэлээр хийсэн ажлын тайланг бодит байдал дээр нь тулган баталгаажуулж үнэлэлт дүгнэлт өгч ажилласан.

“Засгийн газрын тэргүүлэх ач холбогдолтой төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг үнэлж, зөвлөмж боловсруулах ажлын хэсгийг мэргэжлийн хүмүүсийг оролцуулан

аймгийн Засаг даргын 2023 оны 02 дугаар сарын 06-ны өдрийн А/78 дугаар захирамжаар байгуулан “Тэрбум мод” “Хог хаягдал”, “Цахим шилжилт”, зэрэг тэргүүлэх чиглэлийн тайланг үнэлж, дүгнэлээ.

Баянхонгор аймаг нь 2023 онд 300,000 ширхэг модыг тарьж, ургалтын хувийг 70%-д хүргэх зорилт тавьсан бөгөөд 306,055 ширхэг мод, бут, сөөгийг тарьж, ургалтын хувийг 81,8%-д хүргэсэн байна.

Хяналт шинжилгээ, үнэлгээгээр Засгийн газрын тэргүүлэх ач холбогдолтой “Тэрбум мод” төсөл, арга хэмжээний 2023 оны хэрэгжилтийг 100 хувь буюу “Үр дүнтэй” гэж дүгнэв.

Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2023 оны 02 дугаар албан даалгавар, аймгийн Засаг даргын 2023 оны 02 дугаар албан даалгавар, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Тэргүүлэгчдийн 2021 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн 131 дүгээр тогтоолоор батлагдсан “Хог хаягдлын менежментийг сайжруулах аймгийн хөтөлбөр”-ийн хэрэгжилтийг ханган ажилласан.

Хяналт шинжилгээ, үнэлгээгээр Засгийн газрын тэргүүлэх ач холбогдолтой “Хог хаягдал” төсөл, арга хэмжээний 2023 оны хэрэгжилтийг 100 хувь буюу “Үр дүнтэй” гэж дүгнэв.

Баянхонгор аймаг нь мэдээллийн аюулгүй байдлыг хангах, иргэдийн тоон бичиг үсгийн чадавхыг нэмэгдүүлэх, төрийн байгууллагын дотоод үйл ажиллагааг 2023 онд цахимжуулахад анхаарч ажилласан ба хэрэгжилтийг 90 хувьтай хэрэгжүүлж ажилласан байна.

Хяналт шинжилгээ, үнэлгээгээр Засгийн газрын тэргүүлэх ач холбогдолтой “Цахим” төсөл, арга хэмжээний 2023 оны хэрэгжилтийг 90 хувь буюу “Тодорхой үр дүнд хүрсэн” гэж дүгнэв.

Засгийн газрын тэргүүлэх ач холбогдолтой “Шилжин ирэгсэд” төсөл, арга хэмжээний 2023 оны хэрэгжилтийг “Тодорхой үр дүнд хүрсэн” гэж дүгнэв. Тус аймаг арга хэмжээг хэрэгжүүлэн “Нээлттэй Баянхонгор аймаг” хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах, “Аймаг орон нутагт шилжин ирж байгаа иргэд, аж ахуйн нэгж байгууллагыг дэмжих” бодлогын хүрээнд 2023-2024 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг батлуулан 98.8 хувийн гүйцэтгэлтэй ажилласан байна.

Арван гурав. Аймгийн эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлтэд хийсэн хяналт-шинжилгээ үнэлгээний тойм:

Аймгийн эдийн засаг, нийгмийн хөгжлийн 44 шалгуур үзүүлэлтээс 10 үзүүлэлт хүрэх түвшинд хүрээгүй, 34 үзүүлэлт хүрэх түвшинд хүрч 100 хувиар үнэлэгдлээ. Нийт 44 шалгуур үзүүлэлтийн хэрэгжилтийг 90.59 хувиар үнэллээ.

Хоёрдугаар бүлэг: Нутгийн захиргааны байгууллагуудын үйл ажиллагаанд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээ болон бусад ажил

Аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг сумын Засаг даргын Тамгын газар, орон нутгийн өмчийн байгууллагуудын 2022, 2023 оны үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, зөвлөмж өгч ажилласан ба албан хаагчдыг чадавхжуулах, хяналт-шинжилгээ, үнэлгээний ил тод байдлыг хангах чиглэлээр дараах ажлыг хийж гүйцэтгэлээ. Үүнд:

1.Аймгийн хяналт-шинжилгээ, үнэлгээний <http://bayankhongor.igovernment.mn> цахим системээр дараах 15 төрлийн тайланг 20 сум, 23 агентлаг, 11 төрийн болон орон нутгийн өмчийн байгууллага, аймгийн Засаг даргын Тамгын газрын 7 нэгжээс авах нөхцөлийг бүрдүүлж, давхардсан тоогоор 1816 байгууллага, нэгжид 8675 бодлогын баримт бичиг, хууль тогтоомжийн заалтыг хуваарилж, 41927 заалтын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, зөвлөмж өгч ажиллалаа. Үүнд:

Д/д	Тайлагнасан баримт бичгийн нэр	Тайлагнасан байгууллага, АЗДТГ-ын нэгжийн тоо /давхардсан/	Хяналтад байгаа		Үнэлгээ хийсэн давтамж
			Шийдвэрийн тоо /давхардсан/	Заалтын давхардсан дүн/тоо	
1	2	3	4	5	6
1	Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр	108	1	261	9
2	Монгол Улсын 2024 оны хөгжлийн төлөвлөгөө	32	1	172	4
3	Аймгийг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл	32	1	344	1
4	Аймгийн Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр	113	1	1100	2
5	Аймгийг хөгжүүлэх жилийн төлөвлөгөө	56	1	771	2
6	Сумын Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр	40	20	3999	2
7	Дэд хөтөлбөр (хяналтад байгаа шийдвэр, заалт давхардсан тоогоор)	113	190	1660	2
8	Хууль тогтоомж, тогтоол шийдвэр (хяналтад байгаа шийдвэр, заалт давхардсан тоогоор)	673	5282	9392	14
9	Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тогтоол, шийдвэр (хяналтад байгаа шийдвэр, заалт давхардсан тоогоор)	111	506	516	2
10	Аймгийн Засаг даргын захирамж, албан даалгавар (хяналтад байгаа шийдвэр, заалт давхардсан тоогоор)	170	2558	8068	3
11	Засгийн газрын зарим чиг үүргийн орон нутагт хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө	51	38	1722	2
12	Аймгийн Засаг дарга-Сумын	40	20	2900	2

1	2	3	4	5	6
13	Засаг даргатай байгуулсан гэрээ Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт	93	54	6146	2
14	Сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр	92	1	644	2
15	Ил тод байдлын шалгуур	92	1	4232	2
	Дүн	1816	8675	41927	51

Мэдээллийн системээр сум, агентлаг, орон нутгийн өмчийн байгууллагын бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагааны тайланг 2023 оны эхний хагас жил, жилийн эцсийн байдлаар тус тус хүлээн авч, үнэлж, дүгнэх үйл ажиллагааг тогтмолжуулсан. Мөн Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, Улсын хөгжлийн төлөвлөгөө (сүүлийн хагас жилд), Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн тайланг сар бүр аймгийн цахим мэдээллийн системээр авч, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж ажилласан.

Дээрх цахим тайлангаас гадна харьяа байгууллага, сумдаас ирүүлсэн Монгол Улсын Засгийн газрын тэргүүлэх ач холбогдолтой төсөл, арга хэмжээг үнэлэх шалгуур үзүүлэлтийн биелэлт, аймгийн Засаг даргын 2022 оны А/286 дугаар захирамжаар батлагдсан “Бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, нутгийн захиргааны болон орон нутгийн өмчит байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх журмын 15 дугаар хавсралтаар батлагдсан “Байгууллага, нэгжийн тэргүүлэх ач холбогдолтой арга хэмжээний хэрэгжилтийг үнэлэх шалгуур үзүүлэлт”, Хяналт-шинжилгээ, үнэлгээний зөвлөмжийн хэрэгжилт зэрэг тайланг цаасаар хүлээн авч үнэлж ажиллалаа. Эдгээр 3 тайлан одоогоор цахим системд ороогүй болно.

Мөн Сумдын Орон нутгийн хөгжлийн сангийн удирдлагын мэдээллийн системд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, 20 сумд үйл ажиллагааг сайжруулах зөвлөмж өгсөн.

2.Аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлагууд, сумдын Засаг даргын Тамгын газар, орон нутгийн өмчийн болон босоо удирдлагатай төрийн өмчийн нийт 54 байгууллагуудад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж тогтоол шийдвэрийн хэрэгжилт, бодлого төлөвлөлт, үйл ажиллагааны гүйцэтгэл, үр дүн, үр нөлөөг нэмэгдүүлэх, албан хаагчдын сахилга, хариуцлагыг сайжруулж, бодлогын зөвлөгөө, мэргэжил арга зүйн зөвлөмжөөр хангах зорилгоор зөвлөн туслах үйлчилгээг 2023 оны 6 дугаар сард 1 удаа, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх ажлыг 2024 оны 1 дүгээр сард 1 удаа тус тус хийж, сум, байгууллагууд дээр очиж ажилласан. Байгууллагуудын 2023 оны эхний хагас жил, жилийн эцсийн бодлогын баримт бичиг, хууль, тогтоомж, тогтоол шийдвэр, байгууллагын үйл ажиллагааны тайланд хийсэн хяналт шинжилгээ, үнэлгээний зөвлөмж, тайланг байгууллага тус бүрт 2 удаа, нийт 110 зөвлөмж хүргүүлэн ажилласан.

Нутгийн захиргааны байгууллагуудын бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэр, байгууллагын 2023 оны үйл ажиллагаанд хийсэн Хяналт-шинжилгээний нэгдсэн дүнг 2024 оны 3 дугаар сард зохион байгуулагдах **“Удирдах ажилтны хариуцлагын зөвлөгөөн”**-д хэлэлцүүлэхээр төлөвлөн ажиллаж байна.

Хяналт шинжилгээ, үнэлгээнээс гарсан нэгдсэн дүгнэлт зөвлөмжийг аймгийн Засаг даргын Тамгын газрын удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн, “Бодлогын баримт бичгийг холбогдох хууль, тогтоомжид нийцүүлэн батлуулах тухай” аймгийн Засаг даргын оны 03 албан даалгаврыг гарган хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна.

4.Төрийн болон орон нутгийн бодлого, төлөвлөлт, үйл ажиллагааны гүйцэтгэл, хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн хэрэгжилтийн үр дүн, үр нөлөөг нэмэгдүүлэх, төрийн албан хаагчдын үүрэг, хариуцлагыг дээшлүүлэх, төрийн байгууллагуудын ажлын уялдаа холбоог сайжруулах талаар аймгийн Засаг дарга, аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга, аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний хэлтэс, агентлаг, сумдын Засаг даргын Тамгын газарт 2023 онд нийт 110 зөвлөмжийг хүргүүлэн хэрэгжилтийг тооцон ажиллаж байна.

Бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, байгууллагын үйл ажиллагааны үр дүнг нэмэгдүүлэх, сайн туршлагыг түгээн дэлгэрүүлэх, байгууллага хоорондын уялдаа холбоог сайжруулах зорилгоор дараах гурван ангиллаар 2023 оны 10 дугаар сарын 27-ны өдрөөс 11 дүгээр сарын 09-ний өдрүүдэд хийлээ. Үүнд:

1.Агентлаг, төрийн болон орон нутгийн өмчийн байгууллагын дарга хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн асуудал хариуцсан албан хаагчдад 2023 оны 10 дугаар сарын 25-26-ны өдөр танхимын сургалтыг туршлага солилцох үзүүлэх сургуультай хослуулсан байдлаар;

2.Аймгийн Засаг даргын Тамгын газрын бодлогын хэлтсийн дарга, мэргэжилтнүүдтэй 2023 оны 11 дүгээр сарын 03-ны өдөр хэлэлцүүлэг байдлаар;

3.Сумдын Засаг дарга, Засаг даргын Тамгын газрын дарга, Санхүүгийн албаны дарга, Хөдөө аж ахуйн тасгийн дарга, Нийгмийн бодлогын мэргэжилтэн, Хууль эрх зүй, дотоод ажил хариуцсан мэргэжилтнүүдийг бүсчилсэн байдлаар 4 бүс болгон тус бүр 5 сумын 30 хүртэл албан хаагчийг “Төрийн бүтээмж ба үнэлгээ, мониторинг” сургалтад хамруулан харилцан туршлага солилцох байдлаар зохион байгууллаа.

Агентлаг, төрийн болон орон нутгийн өмчийн байгууллагын сургалтад хамрагдсан 163 албан хаагчаас сургалтын дараах санал асуулгаар сургалтын агуулга ойлгомжтой, үр дүнтэй сургалт болсон хэмээн оролцогчид 100 хувь үзсэн байна.



Зураг дээр: “Төрийн бүтээмж ба үнэлгээ, мониторинг” сургалт

Монгол Улсын Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын 2023 оны 01/561, 01/1037 дугаар албан бичгээр ирүүлсэн аймгийн 2022 оны жилийн эцсийн үйл ажиллагаа болон 2023 оны эхний хагас жилийн Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, Улсын хөгжлийн төлөвлөгөө, Хууль, тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний зөвлөмжийг тус тус хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө гарган хэрэгжүүлж, удаашралтай заалт арга хэмжээний хэрэгжилтийг дунджаар 90 хүртэл хувьд хүргэн эрчимжүүлж ажилласан.

Дүгнэлт:

Баянхонгор аймгийн Засаг даргын Тамгын газраас 2023 онд харьяа байгууллага, нэгжийг мэргэжил арга зүйн сургалт, зөвлөгөө, зөвлөмжөөр хангаж, бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээг цахимаар болон бусад хэлбэрээр хийсний үр дүнд Нутгийн захиргааны байгууллагуудын ил тод байдал нэмэгдэж, төрийн албан хаагчдын үүрэг хариуцлага, байгууллага хоорондын уялдаа холбоо сайжирч, цаг хугацааны болон төсвийн хэмнэлт бий болсон.

ТАНИЛЦСАН:
АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА

Д.МӨНХСАЙХАН

ХЯНАСАН:
ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ ҮНЭЛГЭЭНИЙ
ХЭЛТСИЙН ДАРГА

Л.МАНДАЛ

ТАЙЛАН БИЧСЭН:
НИЙГМИЙН БОДЛОГЫН САЛБАРЫН
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ
ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН

Б.БУЛГАМАА



**БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
2023 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮНЭЛГЭЭНИЙ ДҮН**

Үзүүлэлт		Хувь	Жин	Оноо
1	2	3	4	5
Бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн үнэлгээ	1. Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлт	94.11	0.5	
	2. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт	94.71		
	3. Аймаг, нийслэлийн хөгжлийн жилийн төлөвлөгөөний хэрэгжилт	90.56		
	4. Аймаг, нийслэлийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт	91.65		
	5. Эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлтийн биелэлт	90.59		
Байгууллагын чиг үүргийн үзүүлэлтийн үнэлгээ	1. Монгол Улсын Засгийн газрын зарим чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх гэрээний хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт	96.7	0.15	
	2. Байгууллагын тухайн жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт	97.1		
	3. Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн хэрэгжилт	95.71		
Байгууллагын нээлттэй байдлын үнэлгээ	1. Байгууллагын ил тод байдал	100	0.2	
	2. Шилэн дансны хөтлөлт	-		
	3. Шударга байдлын түвшин	-		
	4. Хэрэглэгчийн үнэлгээ	-		
Монгол Улсын хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт туссан Засгийн газрын тэргүүлэх ач холбогдолтой төсөл, арга хэмжээний гүйцэтгэлийн үнэлгээ	Засгийн газрын тэргүүлэх ач холбогдолтой төсөл, арга хэмжээг үнэлэх шалгуур үзүүлэлтийн биелэлт	97.2	0.15	
Ерөнхий үнэлгээ		94.83	1	

ТАНИЛЦСАН:
АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА

Д.МӨНХСАЙХАН

ДҮНГ НЭГТГЭСЭН:
ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ
ХЭЛТСИЙН ДАРГА

Л.МАНДАЛ

